



ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 9162

Бэрх хот

Хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дах заалт, Захирагчийн зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн №06 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024-2025 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад 10-с дээш сурагчдыг бэлтгэн аймаг, улсын дунджаас дээгүүр оноо авсан, "Сургалтын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт"-нд амжилттай шалгагдаж 2-р түвшинд үнэлэгдсэн багш нарыг шагнаж, урамшуулсугай.

2.Урамшуулал олгох багш нарын нэрсийг хавсралтаар баталсугай.

3.Шагналд шаардагдах 2.500.000 (Хоёр сая таван зуун мянган) төгрөгийг Захирагчийн нөөц сангаас холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гаргахыг Нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧИЙН
Ч.ЭНХЖАВХЛАН

Хотын Захирагчийн 2025 оны
10 дугаар сарын 10 ны өдрийн
1152 дүгээр захирамжийн хавсралт

№	Нэрс	Албан тушаал	Регистрийн дугаар	Мөнгөн дүн
1	Б.Хулан	Нийгмийн ухааны багш	СП94040101	500.000
2	Л.Саранчимэг	Математикийн багш	CP96073100	500.000
3	Л.Батжаргал	Биеийн тамирын багш	СФ77121614	500.000
4	С.Эрдэнэ-Очир	Бага ангийн багш	СЭ75060901	500.000
5	Л.Ичинхорол	МХУЗ-ын багш	СА79042006	500.000